| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                                 | -          | 90,000.00             | -           | 100.0        |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                                | -          | 3,955,431.26          | -           | 100.0        |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | -          | <b>23,598,446.72</b>  | -           | <b>100.0</b> |
| 210401                | Бичиг хэрэг                                                          | -          | 427,280.00            | -           | 100.0        |
| 210402                | Тээвэр, шатахуун                                                     | -          | 5,575,000.00          | -           | 100.0        |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | -          | 3,107,616.72          | -           | 100.0        |
| 210404                | Ном, хэвлэл                                                          | -          | 12,405,600.00         | -           | 100.0        |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | -          | 2,082,950.00          | -           | 100.0        |
| <b>2107</b>           | <b>Томилолт, зочны зардал</b>                                        | -          | <b>8,800,000.00</b>   | -           | <b>100.0</b> |
| 210702                | Дотоод албан томилолт                                                | -          | 8,800,000.00          | -           | 100.0        |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | -          | <b>102,053,724.00</b> | -           | <b>100.0</b> |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | -          | 94,974,044.00         | -           | 100.0        |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | -          | 7,000,000.00          | -           | 100.0        |
| 210808                | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж                   | -          | 79,680.00             | -           | 100.0        |
| <b>2109</b>           | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | -          | <b>17,937,087.32</b>  | -           | <b>100.0</b> |
| 210911                | Төвлөрсөн арга хэмжээ                                                | -          | 17,937,087.32         | -           | 100.0        |
| <b>213</b>            | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | -          | <b>400,000.00</b>     | -           | <b>100.0</b> |
| <b>2132</b>           | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | -          | <b>400,000.00</b>     | -           | <b>100.0</b> |
| 213204                | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | -          | 400,000.00            | -           | 100.0        |
| <b>22</b>             | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                              | -          | <b>9,940,000.00</b>   | -           | <b>100.0</b> |
| <b>2200</b>           | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                           | -          | <b>9,940,000.00</b>   | -           | <b>100.0</b> |
| 222001                | Тоног төхөөрөмж                                                      | -          | 9,940,000.00          | -           | 100.0        |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | -          | <b>494,097,429.10</b> | -           | <b>100.0</b> |

|         |                                                  |   |                       |   |              |
|---------|--------------------------------------------------|---|-----------------------|---|--------------|
| 120004  | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ<br/>АЖИЛЛАГААНААС</b> | - | <b>3,361,090.71</b>   | - | <b>100.0</b> |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны<br>орлогоос санхүүжих     | - | 3,361,090.71          | - | 100.0        |
| 122     | <b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС<br/>САНХҮҮЖИХ</b>     | - | <b>490,736,338.39</b> | - | <b>100.0</b> |
| 122002  | Хандив тусламж /гадаад/                          | - | 490,736,338.39        | - | 100.0        |
| 61      | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                          | - | <b>1</b>              | - | <b>100.0</b> |
| 610001  | Төсвийн байгууллага                              | - | 1                     | - | 100.0        |
| 62      | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                          | - | <b>4</b>              | - | <b>100.0</b> |
| 620001  | Удирдах ажилтан                                  | - | 1                     | - | 100.0        |
| 620002  | Гүйцэтгэх ажилтан                                | - | 3                     | - | 100.0        |
| 65      | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                       | - | <b>4</b>              | - | <b>100.0</b> |
| 650009  | Төрийн үйлчилгээний бусад албан<br>хаагч (ТҮ)    | - | 4                     | - | 100.0        |

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн зохицуулагч Г. Нарангуа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авах ажиллагааны талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 11 дүгээр сарын 3-наас 2021 оны 02 дугаар сарын 19-ний хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн аудитор Ц. Бямбасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 12/2021 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Чиг үүрэг дахин хуваарилах салбарын хуулийн төслүүдийг боловсруулах;
- Төсвийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх;
- Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх;
- Монгол улсын Засгийн газар, Өөрчлөлтийн менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж эхлэх.

Төслийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны голлох үр дүнгээс дурдвал:

- Чиг үүргийг холбогдох санхүүгийн эх үүсвэр, захиргааны эрх мэдлийн хамт оновчтой дахин хуваарилах чиглэлээр боловсруулсан хуулийн төслүүд батлагдсан. *Тухайлбал: Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан, чиг үүргийг дахин хуваарилах чиглэлээр яамдын ажлын хэсгүүдээс гарсан санал, дүгнэлттэй холбоотой 50 гаруй хуулийн төсөл боловсруулж, зарим хуулийн төслүүдийг Улсын их хурлаар баталсан, мөн зарим нь хэлэлцүүлгийн шатанд байна.*
- Улсын их хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох "Алсын хараа 2050"-д төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой хуваарилах асуудлыг цаашид төрийн тогтвортой хийх ажил болгох, уг асуудлыг хариуцсан бүтцийг бий болгохыг баталгаажуулсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төвлөрлийг сааруулах төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой хуваарилах чиглэлээр тодорхой ажлуудыг тусгасан.
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлэн санал, дүгнэлт авсан.

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл болон дагалдаж гарах Татварын болон Төсвийн тухай хуулийн төслүүд батлагдсанаар Орон нутгийн төсвийн татварын орлого нэр төрлөөрөө болон нийт дүнгээрээ нэмэгдэхээр болсон. Шинэчлэн батлагдсан Татварын ерөнхий хуулийн дагуу Малын тоо толгойн албан татварын хуулийг баталсан нь сум/дүүргийн татварын орлогыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.
- Орон нутагт хэрэгжүүлэхээр заасан чиг үүргүүд тэдгээрийн хэрэгжилтэд учирдаг хүндрэл бэрхшээл болон орон нутгийн төсвийн санхүүжилтийн талаарх нөхцөл байдлын судалгааг Сэлэнгэ аймгийг сонгон авч хийж гүйцэтгэсэн.

Төслийн үйл ажиллагааны үр дүнг төслийн Хөтөлбөрийн зөвлөлөөс болон төслийн захирлын зүгээс үр дүнтэй хэрэгжиж байгаа гэж үнэлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт гараагүй байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Бид санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 362,392.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,247.9 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 131,704.8 мянган төгрөгөөр буюу 133 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дандад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөг/                                   |                 |                  |                  |
|---------------------------------------------------|-----------------|------------------|------------------|
| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт         |
| Б                                                 | 1               | 2                | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                    | 95,753.8        | 217,704.0        | 121,950.1        |
| Авлага                                            | 0               | 0                | 0                |
| Урьдчилгаа                                        | 0               | 0                | 0                |
| Бараа материал                                    | 1,115.7         | 3,761.1          | 2,645.5          |
| Үндсэн хөрөнгө                                    | 2,210.4         | 9,439.6          | 7,229.2          |
| Биет бус хөрөнгө                                  | 200.0           | 80.0             | (120.0)          |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>99,279.9</b> | <b>230,984.7</b> | <b>131,704.8</b> |
| Өр төлбөр                                         | 0               | 0                | 0                |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 99,279.9        | 230,984.7        | 131,704.8        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>99,279.9</b> | <b>230,984.7</b> | <b>131,704.8</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 217,704.0 мянган төгрөг болж өмнөх оноос 121,950.1 мянган төгрөгөөр өссөн нь коронавирусын цар тахалтай холбоотойгоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хурал, хэлэлцүүлэг зэрэг зарим арга хэмжээ хойшилсноос шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл (анхны өртгөөр) 13,499.1 мянган төгрөг болж өмнөх оноос 34 хувиар өссөн нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 9,940.0 мянган төгрөгийн өртөг бүхий 4 компьютер худалдан авсан, мөн төслийн захирлын 2020 оны 4 тоот тушаалын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 6,482.0 мянган төгрөгийн 4 компьютерыг данснаас хасаж бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 230,984.7 мянган төгрөг болж өмнөх оноос 131,704.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төлөвлөсөн зарим арга хэмжээ хойшилсонтой холбоотойгоор төлөвлөсөн хэмжээний зарцуулалт гараагүйгээс тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

| /Мянган төгрөг/                                                              |                   |                  |                    |
|------------------------------------------------------------------------------|-------------------|------------------|--------------------|
| Үзүүлэлт                                                                     | Эхний үлдэгдэл    | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт           |
| Б                                                                            | 1                 | 2                | 3=2-1              |
| <b>Тусламж, санхүүжилтийн орлого</b>                                         | <b>626,455.2</b>  | <b>494,097.4</b> | <b>(132,357.8)</b> |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж          | 620,000.0         | 490,736.3        | (129,263.7)        |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,455.2           | 3,361.1          | (3,094.1)          |
| <b>Урсгал зардал</b>                                                         | <b>700,921.3</b>  | <b>362,392.6</b> | <b>(338,528.7)</b> |
| <b>Нийт үр дүн</b>                                                           | <b>(74,466.1)</b> | <b>131,704.8</b> | <b>206,170.9</b>   |

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх тусламж санхүүжилтийн орлого өмнөх оноос 129,263.7 мянган төгрөгөөр буюу 21.1 хувиар буурсан нь Төслийн хаалтын шатны төлөвлөсөн санхүүжилт өмнөх оноос буурч төлөвлөгдсөнөөс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал өмнөх оноос 338,528.7 мянган төгрөгөөр буюу 48.3 хувиар буурсан нь голчлон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн бууралтаас үүссэн байна. Тодруулбал: Төслийн өмнөх үе шат болон хаалтын үе шатанд төлөвлөсөн ажлууд ялгаатайгаас гадна, тайлант онд коронавирусын цар тахлын улмаас төлөвлөсөн зарим арга хэмжээ хэрэгжээгүй хойшилсноос шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл нь 100 хувь Швейцарын хөгжлийн агентлагаас санхүүжилттэй бөгөөд улсын төсвөөс санхүүждэггүй байна.

Швейцарын хөгжлийн агентлагтай байгуулсан Хамтран ажиллах гэрээний хүрээнд уг төсөл 2020 оноос 2022 он хүртэл хэрэгжих бөгөөд хаалтын шатны санхүүжилтэд нийт 1,600,000.0 мянган төгрөгийн тусламжийн санхүүжилт хүлээн авахаар төлөвлөсөн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжүүлсэн тусламжийн төсөл хөтөлбөрөөс 490,736.3 мянган төгрөг, хүүгийн орлого 3,361.1 мянган төгрөг, нийт 494,097.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 197,771.6 мянган төгрөг, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 11,646.5 мянган төгрөг, хангамж албан томилолтын зардалд 32,398.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 119,990.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 400.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 9,940.0 мянган төгрөг, нийт 372,147.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Мөн өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл болох мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 95,753.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 118 мэдээллээс хугацаандаа оруулсан 108 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 18 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар дараах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 108 мэдээллийг хугацаанд нь 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэх", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.4-т "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар 1 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Коронавирусын цар тахалтай холбоотойгоор тайлант онд төлөвлөсөн зарим арга хэмжээ хойшилсон. Энэ нь төслийн хаагдах хугацааг 12-18 орчим сараар уртсах, үүнд шаардагдах нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ бий болгох магадлалтай тул анхаарал татахуйц асуудал гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Сангийн яамнаас төсөлд ирүүлсэн 10/1010 тоот албан бичгийг үндэслэн 2020 оны худалдан авалтын төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар батлуулаагүй.

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл нь Швейцарын Хөгжлийн Агентлагтай байгуулсан 81062700 дугаар бүхий Хамтран ажиллах гэрээний 5.2 дахь заалт “Засгийн газрын хэрэг эрхлэх газар нь бараа үйлчилгээ худалдан авахтай холбоотой аливаа шийдвэрийг хариуцах бөгөөд ... Монгол улсын бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.1 дэх “Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг ... дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

- 1.2. Эрсдэл: Холбогдох хууль, эрхийн акт зөрчигдөх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн хүрээнд хийгдэх худалдан авалтын үйл ажиллагаанд Төслийн гэрээ, Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүднээс 2022 оны худалдан авалтын төсөв, худалдан авалтын аргыг агуулсан худалдан авалтын төлөвлөгөөг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт хуулийн хугацаанд багтаан хүргүүлж, батлуулж мөрдөн ажиллах нь зүйтэй байна.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Манай төсөл нь жил бүрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөө тайланг төслийн захирал буюу Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд даргаар батлуулдаг. Энэхүү тайлан төлөвлөгөөнд тухайн жилийн худалдан авах бүх ажиллагааны тайлан, төлөвлөгөө багтсан байдаг тул бид энэ хүрээндээ худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөгөө багтсан гэж ойлгоод явж байгаа. Заавал тусад нь дахин салгаж батлуулах шаардлагагүй гэж үзэж байсан.
- 1.5. Харин энэ жилээс тусад нь батлуулж байхаар дарга нартаа танилцуулъя.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|                              |                                                    |                                                                                                                                |                     |
|------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:                                       | <b>Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b> | Аудитын код:        |
| 2021.02.20                   |                                                    |                                                                                                                                | САГ-2021/47/СТА-ТХН |
| Шалгагдсан байгууллагын нэр: | <b>Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл</b> |                                                                                                                                | Мянган төгрөг       |

| №          | Алдаа, зөрчлийн товч утга                              | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                     |
|------------|--------------------------------------------------------|------------|---------------------------------------|---------------------------------------------------|---------------------|
|            |                                                        |            | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр            |
|            | 1                                                      | 2          | 3                                     | 4                                                 | 5                   |
| 1          | Худалдан авалтын төлөвлөгөө батлуулаагүй               | -          | зөвлөмж                               | Төслийн зохицуулагч, нягтлан бодогч               | Г.Нарангуа Б. Болор |
| 2          | Шилэн дансны 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан | -          | Албан шаардлага                       | Төслийн зохицуулагч, нягтлан бодогч               | Г.Нарангуа Б. Болор |
| <b>ДҮН</b> |                                                        | -          |                                       |                                                   |                     |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 197/А0160056  
САГ/2021/47/СТА-ТХН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 118 мэдээлэл байршуулахаас 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэх", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.4-т "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн зохицуулагч Г.Нарангуа, нягтлан бодогч Б. Болор нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР  
БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН  
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

А.ДАВААДОРЖ

Ц.ЖИГДЭН

[illegible]

## This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]